

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2024.04.25 № 1077

танай _____-ны № _____-т

Г Дүгнэлт хүргүүлэх тухай Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Улсын Их Хурлын ээлжит сонгуульд оролцох “Дэлхийн Монголчууд нам”-ын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Улсын Их Хурлын сонгуульд оролцох нам, эвсэл нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлого, Улсын Их Хурлаас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын тооцоо, судалгааг гаргаж, хуульд заасны дагуу хянуулан дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Дүгнэлтийн үндэслэл

Үндэсний аудитын газар нь Улсын Их Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817:2020 стандарт, түүнийг хэрэгжүүлэх журам, заавар, аргачлалыг удирдлага болгон Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны Төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны Төсвийн төсөөллийн тухай хуулийг тус тус шалгуур болгож дүгнэлт гаргалаа.

Дүгнэлт

Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор “Дэлхийн Монголчууд нам”-ын ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрт тусгасан зорилт, арга хэмжээ нь Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

“Дэлхийн Монголчууд нам”-ын мөрийн хөтөлбөр /.....15.....хүдас/-ийг хавсаргав.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Д.ЗАГДЖАВ

Z:\Yawsan_Bichig\2024\0420 GNAG-3.Docx

0001030697



**ДЭЛХИЙН МОНГОЛЧУУД НАМЫН
УИХ-ЫН 2024 ОНЫ ЭЭЛЖИТ СОНГУУЛИЙН
“ИРГЭН БҮРИЙН ТӨЛӨӨ”
МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

Намын уриа:

“ИРГЭН БҮРИЙН ТӨЛӨӨ”



**Улаанбаатар
2024 он**

00000001

ДЭЛХИЙН МОНГОЛЧУУД НАМЫН
УИХ-ЫН 2024 ОНЫ ЭЭЛЖИТ СОНГУУЛИЙН
“ИРГЭН БҮРИЙН ТӨЛӨӨ”
МӨРИЙН ХӨТӨЛБӨР

“ ИРГЭН БҮРИЙН ТӨЛӨӨ”

АГУУЛГА:

1. Улс төрийн бодлого
2. Нийгмийн бодлого
3. Эрүүл мэндийн бодлого
4. Байгаль орчин
5. Боловсрол, соёл, шинжлэх ухаан
6. Эдийн засгийн бодлого
7. Дэд бүтэц
8. Хөдөө Аж Ахуй
9. Гадаад харилцаа
10. Батлан хамгаалах



Уршил



ОРШИЛ

Монгол улсын хамгийн үнэт зүйл бол Монгол улсын иргэн юм. Монгол улсын хөгжлийн гол түлхүүр, үндэс суурь нь монгол хүн өөрөө юм. Аливаа улсын аюулгүй байдал дотроос хүний аюулгүй байдал нь улс үндэстний аюулгүй байдал юм. Дэлхийн Монголчууд Нам нь “Авах гээхийн ухаанд” суурилсан “Хүн төвтэй, Төв үзэл баримтлал” бүхий улс төрийн хүчин болно. Бид хүний оюун ухаан, эрдэм мэдлэг, энэрэл хайрыг үнэт зүйлээ болгож байна. Хүн өөрөө бүхий л зүйлийг цогцлоон бүрдүүлэгч гол хүч тул бид хүн хүнээ энэрэн хайрлаж, хүнээ хөгжүүлж, монгол хүний үнэлэмж, түүний бүтээмжийг дээшлүүлж байж хөгжлийг авчирна.

Дэлхийн Монголчууд Нам нь тогтвортой, эрчимтэй хөгжлийн гол үндэс суурь болох төрийн албыг улс төр, намын харьяалал, авилга, хээл кахууль, хувийн эрх ашгаас ангид байлгах байр суурийг чанд баримтлан, мэргэжлийн боловсон хүчний төрийн бодлого, төрийн залгамж чанарыг тасралтгүй хадгалах бодлого, Монгол төрийн, Монгол хүний язгуур эрх ашгийг шударгаар хариуцлагатай хамгаалагч төрийн албаны тогтвортой тогтолцооруу орох зарчмыг Дэлхийн Монголчууд Нам үйл ажиллагаандаа баримтлах болно.

Дэлхийн Монголчууд Нам нь Монгол улсын үндэсний язгуур эрх ашгийг эрхэмлэн дээдэлж, хувь хүний эрх, эрх чөлөө, эрүүл энх амьдрал, айл өрх болгоны сайн сайхны төлөө чармайн ажиллаж, шударга, хариуцлагатай, хүнээ дээдэлсэн нийгмийг бий болгохын тулд төрийн залгамж чанарыг хадгалан “Алсын хараа 2050 - Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг” -ийг удирдлага болгон улс төр, нийгэм, эдийн засгийг оюун ухаан, эрдэм мэдлэг, энэрэл хайрыг эрхэм болгосон эрүүл шинэ бодлогоор хангаж, Монгол “ХҮН”-ийг бодлогынхоо төвд ямагт байлгаж, хүний эрүүл, аюулгүй амьдралын баталгааг бүрэн хангах зорилгоор “ИРГЭН БҮРИЙН ТӨЛӨӨ” мөрийн хөтөлбөрөө Дэлхийн Монголчууд Нам өргөн барьж байна.

Дэлхийн Монголчууд Нам нь нэгдсэн бодлого шийдвэрээр улс төр, нийгэм эдийн засгийн тогтвортой, бат хүчирхэг улс эх орон бий болгох үйл хэргийн төлөө Монгол улсын иргэн хэнтэй ч хамтран ажиллаж мөрийн хөтөлбөрөө хэрэгжүүлэх болно.

НЭГ. Улс төрийн бодлого

Монгол улсын үндэсний язгуур эрх ашиг, хүсэл эрмэлзлийг нэгдүгээрт тавьж, Монгол улсын Үндсэн хууль, олон улсын хууль тогтоомж, бусад хууль тогтоожуудыг чандлан мөрдөж улс төрийн бодлого, үйл ажиллагаагаа явуулна.

- 1.1 Монгол улсын үндэсний эрх ашиг, хүний сайн сайхны төлөө бүхий л үйл ажиллагааг шууд дэмжих улс төрийн бодлого баримтална.
- 1.2 Үндсэн хуулиар олгогдсон Монгол хүн бүрийн бүрэн эрхийг бодитойгоор хэрэгжүүлэхийн төлөө тууштай хүчин зүтгэнэ.
- 1.3 Ардчиллын үнэт зүйл болох эрх чөлөө, тэгш эрх, эв нэгдлийг төрийн үйл ажиллагаанд бүрэн гүйцэд хэрэгжүүлэхийг зорилгоо болгоно.
- 1.4 Хариуцлагатай, эрх үүргээ бүрэн ухамсарласан улс төрийн эрүүл тогтолцоог бий болгоно.
- 1.5 Төрийн албыг намын нөлөөллөөс ангид байлгана.
- 1.6 Улс төр, нийгэм, эдийн засгийн бат хүчирхэг төрийн бодлогын төлөө зүтгэнэ.

ХОЁР. Нийгмийн бодлого

Хөдөлмөрийн насны иргэдийн таатай ажиллах хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх, насанд хүрээгүй хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд зэрэгт чиглэсэн бодлого, үйл ажиллагаа нь бидний тэргүүн зорилтын нэг байх болно.

Монгол Улсын Үндсэн Хуулийн 2-р бүлгийн 16-р зүйлийн 2-т “Монгол Улсын иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй” гэж зааснаар Монгол хүндээ түүний үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдлүүлэхийг өөрсдийн үүргээ гэж ухамсарлан хэрэгжүүлнэ. Үүний тулд:

- 2.1 Төрийн бүх шатны нийгэм эдийн засгийн бодлоготой холбогдсон шийдвэр нь Үндсэн Хуульд заасны дагуу бүх хүн тэгш эрхтэй байх зарчмыг баримтална.
- 2.2 Ажилгүйдлийг тууштай бууруулах арга хэмжээг дэс дараатай авч хэрэгжүүлнэ.
- 2.3 Улаанбаатар хот болон аймаг, сумдын утаа, хог, ус, хөрсний бохирдолт, замын түгжрэлтэй тэмцэх цогц бодлогыг хэрэгжүүлэх хууль эрх зүйн орчныг сайжруулна.
- 2.4 Зарим их, дээд сургуулиудыг Дархан, Эрдэнэт, Багануур зэрэг хотуудад шилжүүлэх, багш, оюутан болон тэдний ая тухтай амьдрах хууль, эрх зүйн орчныг бүрдүүлнэ.
- 2.5 Чинээлэг дундаж давхаргыг бий болгох хууль эрх зүйн орчныг бүрдүүлнэ.



- 2.6 Хөдөлмөрийн хөлсийг цагаар тооцдог тогтолцоонд шилжиж, цагийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих эдийн засаг, хууль эрх зүйн орчинг бүрдүүлнэ.
- 2.7 Нийгмийн хамгаалал, халамжийн тогтолцоог боловсронгуй болгож, ҮНБ, ДНБ-ний өсөлттэй оновчтой уялдуулан, зорилтот бүлэг рүү чиглүүлэх хууль эрх зүйн орчныг бүрдүүлнэ.
- 2.8 Гадаадад ажиллаж, амьдран, сурч буй Монголчууддаа төрийн үйлчилгээг орон зай, цаг хугацаанаас үл хамааран цахимаар авах боломжийг бүрдүүлэхээс гадна Монгол улсын Засгийн газрын “Дэлхийн Монголчууд” хөтөлбөрийг дэмжиж ажиллана.

ГУРАВ. Эрүүл мэндийн бодлого

Шударга өрсөлдөөн, чөлөөт сонголтод суурилсан, олон улсын стандартад нийцсэн эрүүл мэндийн оношилгоо, эмчилгээ, үйлчилгээ авах боломжийг иргэн бүрт олгох нь эрүүл мэндийн салбарын үндсэн зорилт мөн.

Эрүүл мэндийн салбарын анхан шатны байгууллага, эрүүл мэндийн даатгалын салбар, эмнэлгийн үйлчилгээг сайжруулах зорилгоор:

- 3.1 Эрүүл мэндийн даатгалын системийг боловсронгуй болгосноор хүн болгон даатгалд хамрагддаг, түүгээрээ дамжуулан оношилгоо, эмчилгээг хийлгэх хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх боломжийг бий болгоно.
- 3.2 Эмнэлэг, үндэсний төвүүдийн санхүүгийн бие даасан үйл ажиллагааг хангаж, эмч, сувилагчдын ажлын ачаалал, ур чадварт суурилсан цалин, урамшууллын хууль эрх зүйн тогтолцоог бүрдүүлнэ.
- 3.3 Монгол хүнийг эрүүлжүүлэх “Эрүүл чийрэг Монгол” хөтөлбөрийг хэрэгжүүлэх хууль эрх зүйн орчныг бүрдүүлнэ.
- 3.4 0-21 насны хүүхэд залуучуудыг гадаад, дотоодод даатгалын системээр дамжуулан бүрэн төгс оношилгоо, эмчилгээ авах богино, дунд, урт хугацааны эрүүл мэндийн хөтөлбөрийг төрөөс бий болгох хууль эрх зүйн орчныг бүрдүүлнэ.
- 3.5 Эмнэлгийн яаралтай тусламжийн нэгдсэн сүлжээ бий болгох, алсын дуудлагад бүх төрлийн тээврийн хэрэгсэл ашиглах нөхцлийг бүрдүүлэх, явуулын болон сэхээн амьдруулах тасгуудын хүчин чадлыг нэмэгдүүлэх хууль эрх зүйн орчныг сайжруулна.
- 3.6 Улаанбаатар хотын дүүрэг, аймгийн төвүүдэд орчин үеийн тоног төхөөрөмж бүхий оношилгооны төвүүд, төрөх эмнэлгүүдийг шинээр барих хууль эрх зүйн орчинг бүрдүүлнэ.




- 3.7 Анагаахын боловсрол олгох, мэргэжил дээшлүүлэх, нарийн мэргэжлийн эмчийг дотоод, гадаадад бэлтгэх тогтолцоог боловсронгуй болгоно.
- 3.8 Эх, хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлнэ.
- 3.9 Эм, био бэлдмэлийн худалдаанд хатуу хяналт тогтоох хууль эрх зүйн орчныг бий болгоно.
- 3.10 Спорт, чөлөөт цаг, эрүүл мэндийн хөтөлбөрийг хэрэгжүүлж элдэв төрлийн өвчнөөс урьдчилан сэргийлэхэд хүн амыг бүрэн хамруулахад анхаарч ажиллана.
- 3.11 Өндөр хөгжилтэй орны анагаахын шинжлэх ухаан, техник технологийн ололтыг Монголд нэвтрүүлэх ажлыг системтэйгээр эхлүүлнэ.
- 3.12 Хөгжингүй орны нарийн мэргэжлийн эмнэлгийн салбаруудыг Монголд хамтран байгуулах эрх зүйн орчныг бүрдүүлнэ.
- 3.13 Эрүүл зөв хооллолт, урт насжилт хөтөлбөр хэрэгжүүлэх хууль эрх зүйн орчныг сайжруулна.

ДӨРӨВ. Байгаль орчин

Байгаль экологийн нэгдсэн тогтолцоог бий болгох замаар хүрээлэн буй орчны тогтвортой байдлыг хангасан, экосистемийн үйл ажиллагааг тэтгэж, байгалийн баялгийг зүй зохистой, ариг гамтай, ард түмэндээ үр ашигтайгаар ашиглан өнөө болон хойч үедээ өвлүүлэн үлдээхийн төлөө байх нийгмийг бүтээн байгуулах нь бидний зорилт мөн.

Үүний тулд:



- 4.1 Томоохон гол, мөрнүүдэд далан байгуулж урсацын тохиргоо хийх замаар усан сан байгуулж бүс нутгийн усны хангамжийг сайжруулна.
- 4.2 Гүний усны нөөцийг нэмэгдүүлэхийн тулд гүний усны хэрэглээг багасгана.
- 4.3 Гол, мөрний урсац бүрэлдэх эхийг улсын тусгай хамгаалалтад авч, усны менежментийн цогц бодлогыг хэрэгжүүлнэ.
- 4.4 Уул уурхай болон бусад томоохон төслийг санхүүжүүлэгч, хэрэгжүүлэгч байгууллагаас байгаль орчноо хамгаалах, экологийн тэнцвэртэй байдлыг хангах зорилгоор тухайн нутаг дэвсгэр, засаг захиргааны харьяа “Байгаль орчин- Эко сан” байгуулах хууль эрх зүйн орчныг бүрдүүлнэ.
- 4.5 Хүний эрүүл мэнд, байгаль орчин, мал, амьтанд сөрөг нөлөө үзүүлэх химийн хорт бодис хэрэглэдэг боловсруулах үйлдвэрүүдийг хот, суурин газраас нүүлгэж үйлдвэрийн болон ахуйн хаягдал усыг цэвэршүүлэн дахин ашиглах технологи нэвтрүүлж, түүнд тавих хяналтыг сайжруулна.

- 4.6 Монгол Улсын байгалийн үнэт баялаг болсон хангайн бүсэд ашигт малтмал олборлохыг хуулиар хязгаарлаж, байгалийн унаган төрхийг хэвээр хадгалан аялал жуулчлалын бүс болгон хөгжүүлнэ.
- 4.7 Аялал жуулчлалын дэд бүтэц, барилга, байгууламжийг тухайн нутгийн онцлог, нөөцөд тулгуурлан бэхжүүлнэ.

ТАВ. Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан

Агуу их түүхт Монгол түмнийхээ өв соёлыг дээдэлдэг, эх оронч, эрүүл саруул хойч ирээдүйгээ бэлтгэх нь бидний эрхэм зорилго билээ.

Олон улсын стандартад нийцсэн, өндөр боловсролыг эх орондоо олж аваад эзэмшсэн мэргэжлээрээ хаана ч хөдөлмөр эрхлэх боломжтой байж, эх орныхоо ирээдүйн төлөө зүтгэх Монгол хүнээ сургаж бэлтгэх нь боловсролын салбарын гол зорилт байна. Үүний тулд:

- 5.1 Улсынхаа хөгжлийн загварыг зөв сонгож, эдийн засгаа оновчтой авч явахад манай эрдэмтэн мэргэдийн үүрэг асар их бөгөөд шинжлэх ухааны хөгжилд зарцуулах хөрөнгийн хэмжээг эрс нэмэгдүүлэх хууль эрх зүйн орчныг бүрдүүлнэ.
- 5.2 Боловсрол, шинжлэх ухааны чиглэлд сургалт, эрдэм шинжилгээний байгууллагуудын хамтын ажиллагааг хууль, эрх зүйн зохицуулалтаар сайжруулах боломжийг эрэлхийлнэ.
- 5.3 Дэлхийн шилдэгт тооцогддог Их сургуулиудтай хамтарч ажиллах урт хугацааны хөтөлбөрийг байгаль, хүмүүнлэг, эдийн засаг, хэрэглээ болон инженерчлэлийн бүх салбарт хөгжүүлэхийг чухалчлан анхаарна.
- 5.4 Инноваци, шинжлэх ухааны лабораториудыг төрөөс дэмжих хууль эрх зүйн орчныг бий болгоно.
- 5.5 Эх оронч сэтгэлгээтэй, амьдрах ухаанд суралцсан иргэн төлөвшүүлэхэд чиглэсэн хөтөлбөр боловсруулж, хөтөлбөрийн хүрээнд цэцэрлэг, сургуулийн насны хүүхдүүдийг монгол бахархалтай, үндэсний өв, соёл уламжлалыг дээдэлсэн иргэн болгон хүмүүжих нөхцлийг хангана.
- 5.6 Сургууль, цэцэрлэгийн тоог нэмэгдүүлэх, өргөтгөх замаар хүүхдийн сурч, хүмүүжих ая тухтай орчныг бүрдүүлнэ.
- 5.7 Ерөнхий боловсрол бол нийтийн асуудал, төрийн үйл хэрэг. Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын боловсролыг нэг стандарт хөтөлбөрт оруулж, хүүхдийн хүмүүжлийг сайжруулах асуудлыг төрөөс чухалчлан анхаарна.
- 5.8 Их, дээд сургуулийн тоог бус чанарыг чухалчилж, шинэ стандарт мөрдүүлэх замаар их, дээд сургуулийн чанарыг дээшлүүлнэ.



- 5.9 Өндөр хөгжилтэй оронд сургах оюутан, докторантын тоог нэмэгдүүлэх хөтөлбөрийг дэмжинэ.
- 5.10 Их, дээд сургуулиудыг түшиглэн өндөр технологийг дэмжих сургалтыг бий болгож, энэ салбарт суралцагсдын тоог нэмэгдүүлэн, гадаад орнуудтай оюутан, багш солилцох ажлыг өргөжүүлнэ.
- 5.11 Монгол орны хөгжилд нэн шаардагдаж байгаа мэргэжлийн жагсаалтыг шинэчлэн гаргаж дэлхийн шилдэг их, дээд сургуулиудад оюутан сургах хууль эрх зүйн орчныг улам сайжруулна.
- 5.12 Мэдээлэл холбоо, нано болон биотехнологийн чиглэлээр гадаад, дотоодын их, дээд сургуулиудын хамтын ажиллагааг хөгжүүлэхэд анхаарч ажиллана.
- 5.13 Орчин үеийн лабораторийн тоног төхөөрөмжөөр тоноглогдсон судалгаа шинжилгээний нэгдсэн лабораторийн төвийг их дээд сургууль, эрдэм шинжилгээний хүрээлэнгийн дунд байгуулах бодлого баримтална.
- 5.14 Тусгай хэрэгцээт сурагчдын сурч боловсрох хууль эрх зүйн таатай орчны бүрдүүлж, коллеж, их дээд сургуульд элсэн суралцах боломжийг дээшлүүлнэ.
- 5.15 Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн үйл ажиллагааг бүсчилж, мэргэжлийн өндөр ур чадвартай ажиллах хүчнийг бэлтгэж, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын үйл ажиллагааг хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлттэй уялдуулан дэмжих бодлого баримтална.
- 5.16 Монгол улсын тэргүүлэх болон эрэлттэй мэргэжлийн жагсаалтыг шинэчлэх замаар байгаль шинжлэл, инженерийн чиглэлээр суралцах оюуны тоог нэмэгдүүлэх, сурч боловсрох хууль эрх зүйн таатай орчинг бүрдүүлэх бодлого хэрэгжүүлнэ.
- 5.17 “Өндөр ёс суртахуун, өндөр мэдлэг боловсролтой багш” хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ.

Монгол соёл, өв уламжлал, их спортыг хөгжүүлж Монгол эх орноо дэлхийд данстай байлгах нь бидний бас нэгэн зорилт болно. Үүний тулд:

- 5.18 Соёл урлагийн салбарт өмчийн олон хэлбэр, зах зээлийн шударга, чөлөөт өрсөлдөөнийг бий болгож, төр, иргэний нийгэм, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг дэмжин хөгжүүлж, соёлын үйл ажиллагаанд гэр бүл, иргэдийн тэгш оролцоог хангана.
- 5.19 Монгол хүний төлөвшил хөгжлийн эх үндэс болсон түүх, соёл, урлаг, зан заншил, уламжлалыг таниулан сурталчлах үндэстний соёлын цогцолбор төв байгуулна.



- 5.20 Соёлын байгууллагын барилга, байгууламжийг стандарттай болгож, шаардлагатай музей, театр, хүүхэд залуучуудын ордонг шинээр барьж байгуулах эрх зүйн орчныг бүрдүүлнэ.
- 5.21 Түүх, палеонтологи, археологийн олдворыг онцгойлон хадгалж хамгаална.
- 5.22 Соёлын өвийг эрэн сурвалжлах, судлах, хадгалж хамгаалах, сэргээх зэрэг ажлуудыг үргэлжлүүлнэ.

ЗУРГАА. Эдийн засгийн бодлого

Хүн амын үндсэн хэрэгцээг тогтвортой хангасан, өөрийгөө тэтгэж, олон улсын зах зээлд өрсөлдөх чадвартай эдийн засгийг бүрдүүлэхэд чиглэсэн төсөв, санхүү, мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх нь макро эдийн засгийн хүрээний үндсэн зорилт байх болно.

Банк санхүүгийн тогтолцооны урт, дунд, богино хугацааны тогтвортой, эрсдэлгүй найдвартай байдлыг хангаж чадахуйц олон улсын жишиг, хөгжлийн бодлогын зорилгод нийцсэн зээл, хүүгийн зохистой бодлогыг хэрэгжүүлнэ. Үүний тулд:

- 6.1 Улсын төсвийн орлого, зарлагын хяналтыг ил тод болгосон шилэн дансны хуулийг сайжруулж, бүх шатны харууллагыг дээшлүүлэхэд анхаарч, төсвийн зарлагыг танах хууль эрх зүйн орчныг сайжруулна.
- 6.2 Мөнгөний бодлогыг бодит эдийн засгийг дэмжихэд чиглүүлнэ.
- 6.3 Монголд үйлдвэрлэж байгаа бараатай ижил төрлийн барааны импортын татварыг нэмэгдүүлж дотоодын аж ахуйн нэгжүүдийг дэмжинэ.
- 6.4 Хөрөнгийн зах зээлийн үйл ажиллагааг эрчимжүүлнэ.
- 6.5 Цалин, тэтгэврийн хэмжээг инфляцийн түвшин, хөдөлмөрийн бүтээмжтэй уялдуулан нэмэгдүүлэх хууль, эрх зүйн орчинг бүрдүүлнэ.
- 6.6 Одоо буй зээлийн батлан даалтын сангаар дамжуулан жижиг дунд бизнесийг дэмжих хууль эрх зүйн орчинг улам бүр сайжруулна.
- 6.7 Санхүүгийн секторын шинэтгэлийг бодит сектор, тухайлбал, уул уурхайн бус эдийн засгийн бусад салбар, жижиг, дунд бизнесийн өсөлтийг дэмжих, хувийн даатгалын ба хөрөнгө оруулалтын сангууд, хувийн тэтгэврийн сангийн болон зээлийн батлан даалтын тогтолцоог хэрэгжүүлэх чиглэлээр орчин үеийн санхүүгийн зах зээлийн өрсөлдөөнт орчныг бий болгоно.



6.8 Хөрш орнууд болон бусад орнуудын ЗГ-тай байгуулсан худалдааны гэрээнүүдээ шинэчлэх замаар гадаад худалдааны алдагдлыг бууруулж, улмаар тэнцвэржүүлэх бодлого баримтална.

6.9 Хүн ам төвлөрсөн бүс нутгуудад бүх төрлийн үйлдвэрлэл эрхлэх ажлын байр бий болгох хууль, эрх зүйн орчинг сайжруулна.


Уул уурхайн салбараас эдийн засгийн хамаарах хамаарлыг бууруулах, урт хугацааны тогтвортой хөгжлийг хангах, өрсөлдөх чадвар бүхий олон тулгуурт эдийн засгийг бий болгох нь эдийн засгийн бодлогын тэргүүлэх зорилт байна. Үүний тулд:

6.10 Уул уурхайн бус экспортыг дэмжиж, хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийг хувийн хэвшлийн оролцоо, манлайлалтай боловсруулан хэрэгжүүлнэ. Уул уурхайн салбарын экспортын орлогын тодорхой хэсгээс “Оюуны хөгжлийн сан” байгуулах хууль эрх зүйн орчинг бий болгоно.

6.11 Дэлхийн худалдааны байгууллагад элсэхдээ хүлээсэн үүргийн дагуу гааль, тарифын механизмыг ашиглан үндэсний үйлдвэрлэлээ хамгаалах асуудлыг шийдвэрлэнэ.

6.12 Барилгын материалын үйлдвэрлэлийг хөгжүүлж, цемент, төмөр хийц, шил, дулаалгын материал зэрэг бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр хангах бодлого баримтална.

6.13 Мэдээллийн технологи, харилцаа холбооны өрсөлдөөнийг бий болгож, аюулгүй байдлыг хангана.



ДОЛОО. Дэд бүтэц

Хот суурины төлөвлөлтийг боловсронгуй болгож, дэд бүтцийг чанартай, хүртээмжтэй нэмэгдүүлэх, хүн амд амьдрах орчны зөв дадлыг төлөвшүүлж, хүрээлэн байгаа орчны чанар, бохирдлыг бууруулах менежментийг сайжруулна. Үүний тулд:

7.1 Бүх аймгийн сумын төвүүдийг холбосон “Миний нутаг” хатуу хучилттай авто замын сүлжээг бий болгох төсөл хөтөлбөрийг боловсруулж, хууль эрх зүйн зохицуулалтаар хэрэгжүүлнэ.

7.2 Хөндлөн тэнхлэгээр “Алтай-Хянганы төмөр зам” урт хугацааны төслийг боловсруулж, хууль эрх зүйн зохицуулалтаар хэрэгжүүлнэ.

7.3 Дэд бүтэцтэй холбогдсон “Залуучууд Хотхон” амины орон сууц хөтөлбөрийг Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн хүрээнд хэрэгжүүлэх бодлого баримтална.

7.4 Гэр хорооллын барилгажуулалтыг дэмжихийн тулд дэд бүтэц инженерийн шугам, сүлжээг улсаас санхүүжүүлэх нөөц боломжийг эрэлхийлэх хууль эрх зүйн орчныг бий болгоно. Ингэснээр агаар, хөрсний бохирдол, эрүүл ахуйн асуудлуудыг цогцоор нь шийдвэрлэгдэх үндэс суурь тавигдана.

7.5 Орон сууцны зээлийг санхүүжилтын 30 жил хүртэл олгох хууль эрх зүйн боломжийг Монгол улсын урт хугацааны бодлогын баримт бичигт нийцүүлэн эрэлхийлнэ.

7.6 Инноваци, үндэсний интернет провайдер компани, үндэсний хиймэл дагуул хөөргөх хууль эрх зүйн орчинг сайжруулахыг тууштай дэмжиж ажиллана.

7.7 Манай орны хөгжлийн гол зүтгүүрийн нэг нь аж үйлдвэржилт бөгөөд түүнийгээ нягт холбосон зам тээвэр, харилцаа холбоо, үйлчилгээний сүлжээ бүхий дэд бүтэцтэй аж үйлдвэрийн цогцолбор юм. Үүнд:

- Хүнс, хөдөө аж ахуйн цогцолбор.
- Малын гаралтай түүхийг эдэд тулгуурласан Хөнгөн үйлдвэрийн цогцолбор
- Уул уурхайд тулгуурласан Хүнд үйлдвэрийн цогцолбор
- Банк санхүү, харилцаа холбоо, үйлчилгээний салбаруудыг хамарсан үйлчилгээний цогцолборууд болно.

7.8 Монгол Улс БНХАУ, ОХУ, Казахстан, Япон, БНСУ зэрэг томоохон зах зээлүүдийн дунд оршиж байгаа нь аж үйлдвэрээ хөгжүүлэх манай орны нэгэн том бололцоо билээ.

7.9 Манай орны газарзүйн байршил, цаг уурын нөхцөл байдал нь сэргээгдэх эрчим хүчийг түлхүү ашиглах боломжийг олгодгоороо онцлог бөгөөд дэлхийн дулаарлын эсрэг хүлэмжийн хийг бууруулахын төлөө бүх нийтээрээ тэмцэж байгаа өнөөгийн нөхцөлд эрчим хүчний нөөцийн нэг хэсгийг сэргээгдэх эрчим хүчний станц олноор байгуулж бүрдүүлэх нь илүү оновчтой байна.

7.10 Сэргээгдэх эрчим хүчний бодлогыг татварын орчноор хөхүүлэн дэмжиж, гадаад, дотоодын хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт орж ирэх таатай нөхцлийг бүрдүүлнэ.

7.11 Төр, хувийн хэвшлийн түншлэлийг шинэ шатанд гаргаж, бизнест ээлтэй орчныг бүрдүүлэх нь манай тэргүүлэх зорилтын нэг бөгөөд инфляцид хөтлөгдөх бус зохицуулдаг тогтолцоонд шилжих хууль эрх зүйн орчинг бүрдүүлнэ.


7.12 Нийгмийн жинхэнэ баялаг бүтээж буй аж ахуйн нэгж, ажил олгогч эздүүдийг дэмжих хууль эрх зүйн орчныг бий болгоно.



НАЙМ. Хөдөө аж ахуй

- 8.1 Хөдөө аж ахуйн салбарыг хөгжлийн үндсэн зүтгүүр төслийн хэмжээнд авч үзэж мал аж ахуй болон газар тариаланг стратегийн чухал ач холбогдолтой салбар хэмээн үзэж төрөөс онцгойлон дэмжинэ.
- 8.2 Хөдөө аж ахуйн салбарыг бүрдүүлэгч үндсэн хоёр салбар болох мал аж ахуй, газар тариаланг эрчимтэй хөгжүүлэх хууль эрх зүйн орчныг сайжруулна. Ингэснээр хүнсний бүтээгдэхүүнээр дотоодын хэрэгцээг бүрэн хангаж, гаднаас хамааралгүй болгоно.
- 8.3 Мах сүүний чиглэлийн эрчимжүүлсэн аж ахуйг малын үүлдэр угсааг сайжруулах, малыг эрүүлжүүлэх замаар хөгжүүлэх, экспортыг дэмжих хууль эрх зүйн орчинг сайжруулна.
- 8.4 Улаанбаатар, Дархан, Эрдэнэт, Багануур зэрэг хотуудад МУ-ын хүн амыг хүнсээр хангах, нөөцийг хадгалах өндөр технологид суурилсан, бүрэн автоматчилсан хүнсний нөөцийн агуулахуудыг барьж байгуулах хууль эрх зүйн орчныг бий болгоно. Үүний тулд:
- 8.5 Хүнсний аюулгүй байдал, чанар, стандартыг төр хяналтандаа бүрэн байлгах нь эрүүл аюулгүй хүнсний баталгаа юм. Энэ нь хөдөө аж ахуйн үйлдвэрлэлээс эхэлнэ.
- 8.6 Бүсүүдийн төвд тэжээлийн аж ахуйн цогцолборуудыг байгуулна.
- 8.7 Хадлан тэжээл бэлтгэх, ургац хураалтын ажлыг чанаржуулж эрчимжсэн мал аж ахуй, газар тариаланг дэмжих бодлого боловсруулна.
- 8.8 Хүнс, хөдөө аж ахуйн салбарыг бие даасан, өөр орноос хамааралтай байдлыг арилгахад анхаарч өрсөлдөх чадварыг нь бэхжүүлнэ.
- 8.9 Малын гаралтай түүхий эд, ноолуур, ноос, арьс ширийг бүрэн боловсруулж, зах зээлд нийлүүлдэг болгоно.
- 8.10 Дархан-Уул аймаг, Улаанбаатар хотын гадна байгаль орчинд ээлтэй, хаягдлаа бүрэн боловсруулах чадвартай арьс шир боловсруулах үйлдвэрүүдийг байгуулах хууль эрх зүйн орчныг бий болгоно.
- 8.11 Малын даатгалыг давхар даатгалд хамруулах замаар олон улсын стандартын дагуу мал сүргийг индексжүүлж бүртгэх хууль эрх зүйн орчинг улам бүр сайжруулна.

- 8.12 Хангайн бүсийн аймгуудад өндөр ашиг шимт мах, сүүний чиглэлийн үхрийн эрчимжсэн аж ахуй, говь хээрийн бүсэд өндөр ашиг шимт хонь, ямааны аж ахуйг дэмжиж, тариалангийн бүс нутагт дэвшилтэт технологи бүхий фермерийн аж ахуйг хөгжүүлнэ.
- 8.13 Газар тариалан, фермерийн бүс нутгийг түшиглэн хуурай сүү боловсруулах үйлдвэр, аймгуудад цөцгийн тос болон сүүн бүтээгдэхүүний үйлдвэр байгуулах хууль эрх зүйн орчныг улам бүр сайжруулна.
- 8.14 Мах, махан бүтээгдэхүүний үнийг тогтвортой байлгах зорилгоор махны нийлүүлэлтийн шинэ тогтолцоог бүрдүүлнэ.
- 8.15 Мал эмнэлэг, үржлийн асуудал эрхэлсэн төрийн үйлчилгээний албыг бүх сумдад шинээр байгуулах хууль эрх зүйн орчныг бүрдүүлнэ.
- 8.16 Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих, нэмэгдүүлэх зорилгоор “Залуу малчин-фермер” хөтөлбөр, бодлогыг боловсруулж хууль, эрх зүйн зохицуулалтаар хэрэгжүүлэх боломжийг эрэлхийлнэ.
- 8.17 Ойрын 10-н жилд газар тариалангийн талбайг бүрэн усалгаатай болгох хууль эрх зүйн орчныг бүрдүүлнэ.



ЕС. Гадаад харилцаа

Монгол Улс энхийг эрхэмлэсэн, нээлттэй, бие даасан, олон тулгуурт гадаад бодлого хэрэгжүүлж, гадаад бодлогын нэгдмэл байдал, залгамж чанарыг хадгалж, дэлхийн улсуудтай найрсаг харилцаагаа өргөжүүлнэ. Үүний тулд :

- 9.1 Улс төр, эдийн засгийн болон бусад салбарын хамтын ажиллагааг хөгжүүлж, олон улсын хамтын нийгэмлэгт байр сууриа бэхжүүлнэ.
- 9.2 Бүс нутгийн хамтын ажиллагаанд идэвхтэй оролцоно.
- 9.3 Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэн, хуулийн этгээдийн эрх ашгийг тууштай хамгаалж, иргэдийнхээ гадаадад зорчих нөхцлийг хөнгөвчлөн, эх орноо гадаадад сурталчлан таниулах зэрэг ажлыг эрчимтэй хийнэ.
- 9.4 Гадаад бодлогын үндсэн зарчим болох эрх тэгш, харилцан ашигтай хамтран ажиллах, энх тайвнаар зэрэгцэн орших хөгжлийн бодлого явуулна.
- 9.5 Эдийн засаг, соёл, шинжлэх ухаан, технологи, боловсрол, спорт, хүмүүнлэгийн болон бусад бүхий л салбарт гадаад харилцаагаа улам эрчимжүүлнэ.

- 9.6 Дэлхийн энх тайван, хөгжил дэвшлийн төлөө гадаад бодлогыг гүнзгийрүүлнэ.
- 9.7 Энхийг эрхэмлэсэн, нээлттэй, бие даасан, олон тулгуурт гадаад бодлогын хүрээнд дэлхийн улс орнуудтай найрсгаар харилцаж, харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэн эдийн засгийн аюулгүй байдлыг бүх талаар хангахыг эрмэлзэж, аль нэг улсаас хэт хамааралтай буюу хараат байдалд орохоос сэрэмжилнэ.
- 9.8 Далайн тээврийн асуудлыг төрийн бүрэн эрх мэдэлд авч, далбаа ашиглалтын орлогыг нэмэгдүүлнэ.
- 9.9 ОХУ, БНХАУ-тай тэнцвэртэй харилцаж, түүхэн уламжлал, эдийн засгийн хамтын ажиллагааны өвөрмөц онцлогийг харгалзан сайн хөршийн ёсоор өргөн хүрээтэй хамтын ажиллагааг хөгжүүлнэ.
- 9.10 АНУ, Ази Номхон далайн улс орнууд, Европын холбоо гэх мэт дэлхийн улс орнуудтай улс төр, эдийн засгийн бодлогын хүрээнд түншлэлийн харилцаа, хамтын ажиллагааг улам бүр өргөжүүлэн хөгжүүлнэ.
- 9.11 Ази, Номхон далайн бүс нутагт хоёр талын болон олон талт хамтын ажиллагааг хөгжүүлж, стратегийн тогтвортой байдлыг бэхжүүлэх, аюулгүй байдлын хамтын ажиллагааг өргөжүүлэхэд чиглэсэн бодлого, үйл ажиллагааг дэмжинэ.
- 9.12 Үндэсний компани, аж ахуйн нэгжүүдийг гадаадад хөрөнгө оруулах, олон улсын банк, санхүү, хөрөнгийн зах зээлд нэвтрэх хууль эрх зүйн нөхцөл, боломжийг бүрдүүлнэ.
- 9.13 Гадаадад байгаа Монгол Улсын иргэд, хуулийн этгээдүүдийн хууль ёсны эрх ашгийг тууштай хамгаалж, иргэдийг эх орондоо эргэн ирж, хөгжил дэвшилд хувь нэмрээ оруулахыг дэмжих, гадаадад гэрээгээр ажиллагсдын нийгмийн хамгааллыг сайжруулахад чиглэгдсэн төрийн бодлого хэрэгжүүлнэ.
- 9.14 Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичигт тулгуурлан дипломат харилцааг шинэ шатанд гаргах бодлогыг төрөөс дэмжиж ажиллана.
- 9.15 Олон улсын харилцаанд эдийн засгийн хамтын ажиллагааг түлхүү анхаарч ажиллана.
- 9.16 Эх орноо бүх талаар гадаад ертөнцөд сурталчлан таниулж, түүх, соёлын үнэт зүйлс, байгалийн өвийг хамгаалах, сэргээх талаар гадаад улсын хийгээд олон улсын холбогдох байгууллагатай хамтран ажиллана.

АРАВ. Батлан хамгаалах

Батлан хамгаалах нэгдмэл тогтолцоог бэхжүүлэх, олон улсын болон бүс нутгийн аюулгүй байдлыг сахин хамгаалах үйлсэд идэвхитэй оролцож, урт, дунд хугацааны хөтөлбөр, төслүүдийг хэрэгжүүлэх замаар зэвсэгт хүчнийхээ шинэчлэлийг гүнзгийрүүлж, түүнийг мэргэжлийн чиг баримжаатай, чадварлаг болгон хөгжүүлнэ. Үүний тулд:

- 10.1 Батлан хамгаалах нь бүх нийтийн үйл хэрэг байх зарчимд тулгуурлан төрийн батлан хамгаалах бодлогыг улам бүр хөгжүүлэх бодлогыг баримтална.
- 10.2 Зэвсэгт хүчний нэгдмэл байдлыг хангаж, мэргэжлийн цэрэгт суурилсан орчин үеийн зэвсэгт хүчинтэй болох хууль эрх зүйн орчныг бий болгоно.
- 10.3 Хил хамгаалах бодлогыг улам бүр хөгжүүлж, улсын хилийн хамгаалалтад орчин үеийн зэвсэглэл, цахим технологийг нэвтрүүлэх хууль эрх зүйн орчныг сайжруулна.
- 10.4 НҮБ-ын энхийг сахиулах үйл ажиллагаанд оролцож байгаа манай ЗХ-ий бодлогыг дэмжих бодлого баримтална.

Монгол төрийн сүр хүч мандан бадраг.

Дэлхийн Монголчууд Нам

ATA9693 9006109
9023030583

